



**“УЛААНБААТАР ХИВС” ХК-ИЙН 2020 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

1. Компанийн товч танилцуулга

Монголд гар аргаар хивс үйлдвэрлэж хэрэглэж ирсэн түүх эртнийх ч, мал аж ахуйн шавхагдашгүй баялаг болсон хонины ноосоор, дэлхийн олон зуун жилийн түүхтэй, шилдэг техник, технологи ашиглан хивс үйлдвэрлэж эх орныхоо хэрэглэгчид төдийгүй гадаадын зах зээлд нийлүүлж эхэлсэн түүх 1971 онд Улаанбаатарын Хивсний үйлдвэр байгуулагдсанаар эхэлсэн билээ. БНАГУ-ын /хуучнаар/ техник эдийн засгийн тусламжаар байгуулагдсан энэ үйлдвэр жилд 2 ээлжээр 350,0 мянган м2 хивс үйлдвэрлэх хүчин чадалтай ашиглалтанд орж, улмаар 1978, 1989 онуудад техник, технологийн өргөтгөл шинэчлэлт хийж хүчин чадлаа нэмэгдүүлж байлаа.

1990-ээд он хүртэл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 98%-ийг тухайн үеийн бүх социалист орнуудад экспортолж, бүтээгдэхүүнүүд нь гадаадын олон үзэсгэлэн яармагуудаас шилдэг бүтээгдэхүүний шагнал хүртэж ирсэн. Түүнчлэн манай дотоодын хэрэглэгчдийн хувьд, тус үйлдвэрийн “Алтанбулаг”, “Алтай” хивснүүд нь орон гэртээ хамгийн их таашаан хэрэглэдэг тансаг хэрэглээ болсон төдийгүй Монгол төрийн ордон, яам тамгын газрууд, бөхийн болон спортын орднууд зэрэг бүхий л томоохон орднуудад тав тух, өнгө үзэмжийг нэмж байдаг.

Зах зээлийн шилжилтийн үед, МУ-ын өмч хувьчлалын комиссын шийдвэрээр улсын энэхүү томоохон үйлдвэр нь 1992 онд 100 % хувьчлагдаж, “Улаанбаатар хивс” хувьцаат компани болон зохион байгуулагдан, 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 404829 ширхэг хувьцааг олон нийтэд гаргасан.



Компани одоо 100 гаруй ажиллагсадтай. Компани нь жил тутам Баянхонгор, Завхан, Увс, Говь-Алтай аймгийн малчдаас хонины ноосыг худалдан авч өөр компаниар угаалган,

- Ээрэх
- Будах
- Нэхэх
- Нөхөн засах, гүйцэтгэх

зэрэг хивс үйлдвэрлэлийн цогц бөгөөд цомхон бүтэцтэйгээр үйлдвэрлэлээ явуулж, Алтанбулаг, Саян, Алтан-Өргөө, Отгонтэнгэр зэрэг 100 % ноосон, нарийн нэхээст, экологийн цэвэр хивснүүдийг зах зээлд нийлүүлж байна.

Сүүлийн жилүүдэд нийт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 30% -ийг экспортолж ирлээ.

Мөн үндсэн үйлдвэрлэлээс гадна туслах үйлдвэрлэл эрхэлж, захиалгат хивс, хивсэн тапочки, тааран цүнх, машины суудал, эсгий гудас, ноосон бүтээлэг зэрэг бүтээгдэхүүнүүд үйлдвэрлэж байна.

“Улаанбаатар хивс” ХК-ийн эрхэм зорилго

Хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, сонирхлыг эрхэмлэн дээдэлж, хивсний үйлдвэрлэлийн үр ашгийг дээшлүүлж, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэн худалдаж, улмаар улс нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулах нь компанийн эрхэм зорилго юм.

“Улаанбаатар хивс” ХК-ийн бэлэгдэл нь Алтайн уулсын Ноён уулсын булшнаас олдсон дэлхийн хамгийн анхны ширмэл дээр дүрслэгдсэн байсан буга барьж байгаа хангарьд шувуу байдаг.



УЛААНБААТАР ХИВС ХК

Компани эдүгээг хүртэл 50 жил тасралтгүй хөгжихдөө, давхардсан тоогоор 25000 орчим хүнийг ажлын байраар хангаж, зах зээлийн шилжилтийн хүнд хэцүү үед ч үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөлгүй ажиллаж, 10,0 сая м2

хивс үйлдвэрлэсэн, Монголын хөнгөн аж үйлдвэрийн салбарт өөрийн орон зайг бий болгож чадсан бахархам түүхтэй.

2. “Улаанбаатар хивс” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

2020 онд 39'600 м2 үйлдвэрлэж тушаасан нь 2019 оныхоос 16'200 м2-аар дутуу, 3'395.5 сая төгрөгний борлуулалт хийсэн нь 2019 оныхоос 817,9 сая төгрөгөөр бага байв. Үндсэн үзүүлэлтүүд ийнхүү буурсан нь дэлхий даяар тархсан Ковид-19 цар тахлаас шалтгаалан экспорт бүрэн зогсож, үйлдвэрлэл, дотоодын борлуулалтын салбарууд 2-3 сар сул зогссонтой холбоотой.

Харин 317,9 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь 2019 оныхоос 19,1 сая төгрөгөөр илүү байгаа юм.

2020 онд нэгж, албадын хийсэн ажлаас дурьдвал.

- **Үйлдвэрлэлийн алба нь** 69115 кг 15/3 номерын цагаан утас ээрч, 72376 кг утас будав.
- 40329 м2 хивс нэхсэнээс Алтанбулаг хивс 68,57%-ийг эзэлж байна.
- Технологийн хаягдал ашиглан, эсгий гудас, машины суудал, тааран уут, гурьалжин будааны хальсаар 3 төрлийн дэр, хивсэн тапочки хийж борлуулав.
- Аппарат ээрэх шугамд зориулж холих, давхарлан эрчлэх машинуудыг нэмж суурилуулсан.
- Нэхэх Альфа 300 машинд зориулж, суурь утас ороох дамар нэмж авч бүтээмж өсгөв.
- Хуучин нэхэх машиныг өөрчлөн хавтгай нэхмэл буюу келим үйлдвэрлэж эхлэв.
- Баруун аймгуудын малчдаас нийт 265,4 тн ноос худалдан авав.
- Компанийн ойр тойронд явган хүний зам, гүйдэг хаалга зэргийг хийж шинэчилснээс гадна ноосны агуулахыг засч тохижуулав.
- Хивсний чанарыг сайжруулах буюу очёсыг багасгах оновчтой технологи хөгжүүлэв.
- **Маркетингийн алба нь** 2020 онд 56 захиалга авч чанартай гүйцэтгэв.
- Компанийн Facebook 42000 дагагчтай болж, шинэ загварын сурталчилгаа, хямдрал урамшууллын үе болон хөл хорионы үед онлайн худалдаа хийх шинэ сувагтай болсон.
- 116 шинэ загварыг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.
- “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэлдэйн киноны дүрүүдтэй хивс хийх албан ёсны зөвшөөрлийг БНСУ-ын холбогдох компаниас авсан.
- **Сургалт, хүний нөөцийн алба нь** 2020 онд шинээр 20 хүнийг ажилд авч, 7 хүнд ажлын байрны сургалтаар мэргэжил эзэмшүүлэв.

- Компанийн 50 жилийн ойтой холбогдуулж 24 хүнийг төрийн одон медальд тодорхойлон шагнуулав.
- Компанийн танилцуулгыг шинэ ажилтнуудад зориулж, презентаци хэлбэрээр боловсруулав.
- Хүүхдийн баярыг тохиолдуулан 58 хүүхдэд бэлэг өгөв.
- Ажилтнуудыг PCR шинжилгээнд бүрэн хамруулав.
- Цар тахалтай холбоотойгоор сул зогссон ажилтнуудад 50%-ийн цалин олгов.
- Санхүү-эдийн засгийн алба нь татвар, санхүүгийн бүх тайлангуудыг цаг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагууд руу илгээсэн.
- Шинээр нэмэгдсэн болон өөрчлөгдсөн түрээслэгчдийн тооцоог хийв.
- Ноос нийлүүлсэн малчдын ноосны тооцоог хийж бүртгэлд тусган НӨАТ-ын буцаан авалтын тооцоог малчин бүрээр хийсэн.
- Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан тооцоо хийж ажилтнуудын цалинг 10-25%-аар нэмэгдүүлэв.
- Компанийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийг тооцоо хийн даатгалд хамруулав.
- 1999 огоос хойш хуримтлагдсан найдваргүй авлагын жагсаалтыг гарган, 190,4 сая төгрөгийг ТУЗ-өөс тогтоол гаргуулан зөвшөөрлийг авч Найдваргүй авлагын нөөцийн санд хааж бүртгэв.
- Бусад: 2021-03-03 –ны бүртгэлийн өдрөөр компани нь 47 БДК-д 904 хувьцаа эзэмшигчтэй болсон байна.
- Компанийн зах зээлийн үнэлгээ 9,7 тэрбум төгрөг буюу өнгөрсөн онтой харьцуулахад 49,2%-аар өссөн байна.
- Өнгөрсөн 52 долоо хоногийн дундаж үнээр хувьцааны дундаж үнэ 16000-24000 төгрөгийн хооронд хэлбэлзэв.
- Нийт хувьцааны 94 % нь 6 хувьцаа эзэмшигчид төвлөрсөн байна.

3. Компанийн удирдлагын талаарх мэдээлэл

Компанийн ТУЗ нь 2020 онд сонгогдсон ба дараахь гишүүд ажилладаг.

№	Овог нэр	Албан тушаал
1	Цоодолын Зоригт	ТУЗ-ийн дарга
2	Шагдарсүрэнгийн Уламбаяр	ТУЗ-ийн гишүүн
3	Лувсангийн Цэндээхүү	ТУЗ-ийн гишүүн
4	Зоригтын Мөнхмаа	ТУЗ-ийн гишүүн, компанийн дэд захирал
5	Шагдарсүрэнгийн Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн, Аудитын хорооны дарга
6	Зоригтын Эрдэнээ	ТУЗ-ийн гишүүн, компанийн гүйцэтгэх захирал
7	Цэвэгжавын Энхболд	ТУЗ-ийн хараат бус гишүүн
8	Гомбодоржийн Батхүрэл	ТУЗ-ийн хараат бус гишүүн Аудитын хорооны гишүүн
9	Ёндонжамцын Энхтөр	ТУЗ-ийн хараат бус гишүүн

2020 онд ТУЗ нь дараахь зардлын төсөвтэйгөөр ажилласан.

Зардлын товч утга	Нийт дүн [₮]
Цалин, урамшуулал	6 800 000
Тээвэр, шатахуун, сэлбэг	400 000
Бичиг хэрэгсэл, үйлчилгээний зардал	800 000
Хэвлэл, холбоо, интернет	2 000 000
Хяналт, шалгалт, томилолт	1 500 000
Бусад, сургалт, аттестатчилал	1 000 000
Нийт	12 800 000 ₮

4. Аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайлан

Аудиторын дүгнэлт

“ Улаанбаатар хивс ” ХК-ийн

Гүйцэтгэх удирдлага танаа

“Улаанбаатар хивс” ХК-ийн 2020 оны 12 дугээр сарын 31-ний өдрөөр тасалбар болсон тайлан тэнцэл, санхүүгийн жилийн орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийж гүйцэтгэлээ

Бидний дүгнэлтээр “Улаанбаатар хивс” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх баланс, үйл ажиллагааны үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл:

Бид аудитаа аудиторын ёс зүйг баримтлан хараат бусаар Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуулыг гүйцэтгэх ажил багтана.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бид аудитын нягтлах ажлыг хийх явцдаа доорхи АОУС-уудыг мөрдөж ажиллалаа.

Үүнд: АОУС 500, АОУС 510, АОУС 530

Удирдлага ба Засаглах удирдлагын санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, толилуулах нь компанийн удирдлагын хариуцлага байна. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын зүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй баталгаа нь энэхүү гаргасан дүгнэлтэд өндөр баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч, Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан ба алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

(Энэхүү тайлан ньтоот хавсралтын хамт хүчин төгөлдөр болно)



"Улаанбаатар хивс" ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
 2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	303,032.3	603,696.0
1.1.2	Дансны авлага	24,600.4	27,174.3
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	12,350.8	6,418.3
1.1.4	Бусад авлага	16,256.2	7,089.2
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	2,132,438.0	1,908,684.2
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,267,142.9	1,154,518.0
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй		
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,755,820.6	3,707,580.0
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,497,570.0	5,368,604.3
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	1,920.0	1,920.0
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө		
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,499,490.0	5,370,524.3
1.3	Нийт хөрөнгийн дүн	9,255,310.6	9,078,104.3

Аудитор

Б.Мягмар

Б.Мягмар



**"Улаанбаатар хивс" ХК
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ӨМЧ, ӨР ТӨЛБӨР**

2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе


/Мянган төгрөг/

2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.1.1	Дансны өглөг	154,866.8	87,000.4
2.1.1.2	Цалингийн өглөг	39,693.7	25,141.4
2.1.1.3	Татварын өр	21,524.9	52,610.6
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.5	Богино хугацаат зээл	1,332,015.5	1,091,071.5
2.1.1.6	Хүүний өглөг	546,988.1	570,350.8
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	2,119.8	2,119.8
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	29,812.3	60,263.1
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр		
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг		
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,127,021.2	1,888,557.6
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
2.1.2.1	Урт хугацаат зээл	383,272.7	248,000.0
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	383,272.7	248,000.0
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,510,293.9	2,136,557.6
	ЭЗДИЙН ӨМЧ		
2.3	Өмч		
2.3.1	-төрийн		
2.3.2	-хувийн		
2.3.3	-хувьцаат	40,482.9	40,482.9
2.3.4	Халаасны хувьцаа	-22.4	
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	34,184.1	34,161.7
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	6,707,643.0	6,707,643.0
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-37,270.9	159,259.1
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	6,745,016.7	6,941,546.7
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	9,255,310.6	9,078,104.3

Аудитор

Handwritten signature

Б.Мягмар



"Улаанбаатар хивс" ХК
АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
 2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого (цэвэр)	4,214,483.5	3,396,529.9
2	Борлуулалтын өртөг	3,380,989.5	2,887,623.0
3	Нийт ашиг (алдагдал)	833,494.0	508,906.9
4	Түрээсийн орлого	368,863.4	466,928.0
5	Хүүний орлого	2,319.9	3,046.0
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	510,273.6	543,925.7
9	Борлуулалт, маркетингийн зардал	542,708.2	350,511.6
10	Ерөнхий ба удирдлагын зардал	152,567.6	177,677.1
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	630,784.4	573,148.5
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-49,057.6	-57,696.6
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,157.6	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	342,990.7	363,772.9
19	Орлогын татварын зардал	44,147.5	45,794.2
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	298,843.2	317,978.7
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	298,843.2	317,978.7
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	298,843.2	317,978.7
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.7	0.7

Аудитор



Б.Мягмар



"Улаанбаатар хивс" ХК
АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН
 2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган
тегрэг/

№	Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	20.. оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	40,482.9	-22.4	34,184.1	6,707,643.0		-287,534.6	6,494,753.0
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын							
2	Залруулсан үлдэгдэл	40,482.9	-22.4	34,184.1	6,707,643.0		-287,534.6	6,494,753.0
3	Тайлант үеийн цэвэр ашиг						298,843.2	298,843.2
4	Бусад дэлгэрэнгүй орлого							
5	Өмчид гарсан өөрчлөлт						48,579.5	48,579.5
6	Зарласан ногдол ашиг							
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн							
8	2019 оны 12-р сарын 31-ны	40,482.9	-22.4	34,184.1	6,707,643.0		-37,270.9	6,745,016.7
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын							
2	Залруулсан үлдэгдэл	40,482.9	-22.4	34,184.1	6,707,643.0		-37,270.9	6,745,016.7
3	Тайлант үеийн цэвэр ашиг						317,978.7	317,978.7
4	Бусад дэлгэрэнгүй орлого							
5	Өмчид гарсан өөрчлөлт							
6	Зарласан ногдол ашиг						121,448.7	121,448.7
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн							
8	2020 оны 12-р сарын 31-ны	40,482.9		34,184.1	6,707,643.0		159,259.1	6,941,546.7

Аудитор



Б Мянгар

"Улаанбаатар хивс" ХК
АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
 2020 оны 12-р сарын 31-ээр дуусгавар болсон тайлант үе

/Мянган төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	5,514,374.7	4,807,596.0
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	4,951,794.1	4,264,330.6
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	562,580.6	543,265.5
1.2	Мөнгөн зарлагын дүн	5,261,860.3	4,125,396.7
1.2.1	Ажиллагчдад төлсөн	845,111.1	1,017,574.4
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	265,406.6	110,547.3
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	1,776,596.1	1,502,631.6
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	603,013.5	402,026.3
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	12,655.9	7,334.0
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	67,757.5	60,466.8
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	644,162.7	386,734.4
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,047,156.9	638,081.8
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	252,514.4	682,199.4
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн		
2.1	Мөнгөн орлогын дүн	2,319.9	3,046.0
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,319.9	3,046.0
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		
2.1.8			
2.2	Мөнгөн зарлагын дүн		
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6			
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн	2,319.9	3,046.0
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		



РЕЛАЗНО
 СЕРВИСНИЗ АУДИТ ХХК
 Page 04

5.:

3.1	Мөнгөн орлогын дүн	501,054.7	5,972.1
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	500,000.0	
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн		
3.1.3	Төрөл бүрийн хандив (Хөнгөл)	1,054.7	5,972.1
3.1.4			
3.2	Мөнгөн зарлагын дүн	475,240.1	390,553.8
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	405,000.0	281,250.0
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг	70,240.1	109,303.8
3.2.5			
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	25,814.6	-384,581.7
4	Валютын ханшийн зөрүү		
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	280,648.9	300,663.7
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ	22,383.4	303,032.3
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН	303,032.3	603,696.0

Аудитор


Хулга

Б.Мягмар



5. Ноогдол ашиг хуваарилалт

“Улаанбаатар хивс” ХК –ийн үйл ажиллагаа жигдэрч, сүүлийн жилүүдэд хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашигдараахт байдлаар хуваарилаад байна.:



6. Компанийн 2021 онд тавих зорилт

2021 онд хүрсэн түвшин, зах зээлийн хандлага, цар тахлын тархалт зэргийг харгалзан үйл ажиллагааны дараахь үндсэн зорилтыг дэвшүүлж байна:

1. **Үйлдвэрлэлт:** 50000 м2 хивс
2. **Борлуулалт:** 4400 сая төгрөг
3. **Хөрөнгө оруулалт:** 500 сая төгрөг
4. **Цэвэр ашиг:** 405 сая төгрөг
5. **Үйлдвэрлэлийн нэгж өртөг:** 72000 төгрөг

Манай хамт олон **Монгол улсад машинт хивсний үйлдвэр үүсч хөгжсөний буюу “Улаанбаатар хивс” ХК байгуулагдсаны 50 жилийн ойн жил болох 2021 онд техник, технологийн шинэчлэл, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг нэмэгдүүлж, гадаад дотоодын борлуулалтын сүлжээгээ нэмэгдүүлэхэд анхаарал тавьж ажиллана.**